



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль.

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Улсын бүртгэлийн ерөнхий газар

Газрын нэр:

... Улсын бүртгэлийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Хяналтын улсын байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улсын бүртгэлийн хэлтсийн албан ёсны байршил

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:


Албан тушаалын зорилго:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэж, биелэлтэд хяналт тавьж, тайлагнах;
- 2.Улсын бүртгэл болон бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, арилгах, арга хэмжээ авч, тайлагнах;
- 3.Хэлтсийн дотоод үйл ажиллагаанд оролцох, төлөвлөх, тайлагнах;
- 4.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн чиг үүрэгт хамаарах салбарын бодлого, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын биелэлтийг хангах, байгууллагын албан ёсны хуудас болон бусад хэлбэрээр дамжуулан сурталчлах мэдээллээр хангах ажлыг багаар гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн тайлагнах;	-Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	2.Нэгжийн чиг үүрэгт хамаарах салбарын хууль, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтыг хэрэглэж байгаа практикийг судалж, боловсронгуй болгох саналыг удирдлагад танилцуулах, бодлогын болон эрх зүйн баримт бичгийн төсөлд өгөх саналыг нэгтгэн удирдлагад танилцуулж, хүргүүлэх;	-Үндэслэл бүхий санал боловсруулж шийдвэрлүүлсэн байна	Г
	3.Эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагыг биелэлтийг хангах, үр дүнг удирдлагад нэгтгэн танилцуулах, мэдээлэл боловсруулах, ашиглахдаа хуульд заасны дагуу хүний хувийн мэдээллийг хамгаалах;	-Зөвлөмж шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Г, Х
	4.Хууль тогтоомжоор хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох албан тушаалтанд шаардлагатай мэдээллийг нэгтгэн өгөх, мэдээлэл солилцох, үр дүнг тайлагнах.	-Мэдээ, тайлангийн тоо, чанарт ахиц өөрчлөлт орсон байна.	Х, Ш
	1.Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийх;	-Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, үр дүнг эрх бүхий этгээдэд	Г



2 дугаар зорилтын хүрээнд		танилцуулсан байна.	
	2.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд гарч байгаа зөрчил, дутагдлын талаарх мэдээ, мэдээллийг удирдлагад танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах;	-Зөрчил дутагдлын талаар үндэслэл бүхий санал боловсруулж, шийдвэрлүүлсэн байна.	Г
	3.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцлийг судалж, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулах;	-Хуулийн хэрэгжилтийг хангаж, бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.	Г
	4.Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх, дүгнэлт үйлдэх;	-Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт нь хуульд нийцсэн байна.	Г
	5.Улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт, эд юмсыг акт үйлдэн хураан авч, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;	-Холбогдох хууль тогтоомжийн биелэлт хангагдсан байна.	Г
	6.Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох, албан хаагчдад хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх; хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох ажлыг гүйцэтгэх;	-Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	7.Хяналт шалгалтын ажлын тайлан, тоон мэдээг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, хэрэгжилтийг хангах.	-Тайлан, тоон мэдээ үнэн зөв гарч, холбогдох албан тушаалтанд хугацаандаа	Г

